

ТАКС ТАЙМ ТМЗ ХХК — "Зөвлөмж хүргүүлэх тухай" (№ 26/27, 2026.09.09)

Транскрипци. Эх хувь нь docs/legal/tax.pdf (сканнердсан 3 хуудас, зураг хэлбэрээр). Гар бичмэл огноо, дугаар, тамга, гарын үсгийг дөрвөлжин хаалтанд тэмдэглэв. Эх бичвэрийн үг, үсэг, цэг таслалыг засварлахгүйгээр хэвээр буулгав.

ТАКС ТАЙМ ТМЗ ХХК

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо,

Хуульчдын ордон байр, 13 давхар, 1316 тоот

Утас: (976) 99015440, (976) 91990844

Вэбсайт: www.taxtime.mn

Э-шуудан: Taxtime8899@gmail.com

Огноо: [гараар] 2026.09.09 — №: [гараар] 26/27

"ВАЙБ ПЭЙ" ХХК-нд

"Зөвлөмж хүргүүлэх тухай"

Танай компаниас манай татварын итгэмжлэгдсэн хуулийн этгээдийн тусгай зөвшөөрөл бүхий компанид ирүүлсэн "Зөвлөмж хүсэх тухай" албан бичгийн дагуу Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн хүрээнд Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй Татварын багц хуулийг танай эрхэлж буй үйл ажиллагаанд хэрхэн хэрэглэх талаарх зөвлөмжийг дараахь байдлаар хүргүүлж байна. Үүнд:

Нэг. Ажил олгогч (Харилцагч) байгууллагын хувьд:

Ажил олгогч байгууллага нь танай компанитай үйлчилгээний гэрээ байгуулж ажилтан бүрт тогтмол хоолны лимит тогтоож, тогтоосон мөнгийг "Вайб Пэй" ХХК-ийн дансанд урьдчилан шилжүүлэх бөгөөд ажилтан Вайб Пэй картаар хоол, хүнс худалдан авах ба ажилтны Вайб Пэй картаар худалдан авч буй хоол, хүнс нь тухайн ажил олгогч байгууллагын нэр дээр татварын цахим бүртгэлийн ebarimt системд худалдан авалтаар бүртгэгдэх нь:

- ХХОАТ-ын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 "Ажил үүргээ биелүүлэх нөхцөлийг нь сайжруулах зорилгоор ажил олгогчоос ажилтанд олгож байгаа дараах шууд бус орлогыг албан татвар ногдох орлогод хамруулахгүй"-ын 11.2.1 "цайны газар, кафе, амралтын өрөөнд бүх ажилтныг адил нөхцөлөөр хоолоор хангасан," гэж заасан заалтад хамаарахаар байх тул тухайн ажилтанд олгосон хязгаарлагдмал эрхтэй цахим картанд байршуулсан мөнгийг ажилтны шууд бус орлого гэж үзэхээргүй байж болохоор байна.
- ААНОАТ-ын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Дараах нөхцөлийг нэгэн зэрэг хангасан зардлыг албан татвар ногдох орлогоос хасаж тооцно:" гэж заасан заалтын шаардлагуудыг хангасан нөхцөлд татвар ногдох орлогоос хасагдах зардалд оруулан тооцож болохоор байна.

- НӨАТ-ын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6 "Дараах бараа, ажил, үйлчилгээг импортоор оруулах, худалдаж авахад төлсөн албан татварыг албан татвар суутган төлөгчийн төлөх уг албан татварын нийт дүнгээс хасахгүй:"-ын 14.6.2 "хувийн болон ажиллагсдын хэрэгцээнд зориулан худалдаж авсан бараа, ажил, үйлчилгээ;" гэж заасан заалтын дагуу ажилтны хоол, хүнс худалдан авахдаа төлсөн НӨАТ нь тухайн ажил олгогчийн төсөвт төлөх албан татвараас хасагдахгүй байх хуулийн зохицуулалттай байна.

Хоёр. Сүлжээ хөгжүүлэгч "Вайб Пэй" ХХК-ийн хувьд:

Сүлжээ хөгжүүлэгч танай "Вайб Пэй" ХХК нь ажил олгогч байгууллагуудаас ажилтнууддаа олгодог хоолны хөнгөлөлтийг цахимжуулах, нэгдсэн сүлжээнд оруулах зорилготой төлбөрийн шийдлийг хөгжүүлж, сүлжээний дэд бүтэц, POS систем болон цахим картыг хариуцаж, мерчантуудтай гэрээ байгуулан ажиллана гэжээ. Сүлжээ хөгжүүлэгч "Вайб Пэй" ХХК-ийн банкин дахь харилцах дансанд Ажил олгогч (Харилцагч) байгууллага нь гэрээнд заасан тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгө байршуулах бөгөөд тухайн мөнгөн хөрөнгөнөөс ажилтнуудын Вайб Пэй картыг цэнэглэж, ажилтнууд Вайб Пэй картаар худалдан авалт хийнэ. Сүлжээ хөгжүүлэгч "Вайб Пэй" ХХК нь харилцагч байгууллагуудаас үйлчилгээний хураамж, гүйлгээний шимтгэл авч үйлчилгээ үзүүлэх нь:

- ААНОАТ-ын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно:"-ийн 7.4.1 "үйл ажиллагааны орлого;" заасан заалтын дагуу харилцагч байгууллагуудаас авч буй үйлчилгээний хураамж, гүйлгээний шимтгэл нь борлуулалтын орлого болохоор байна. Тухайн үйлчилгээний хураамж, гүйлгээний шимтгэлийг авах бүрдээ цахим төлбөрийн ebarimt системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй болохыг Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д заасан байна.
- НӨАТ-ын тухай хуулийн хувьд дээрх борлуулалтын орлогын хэмжээ 2026 ондоо 50,0 сая төгрөг хүрсэн бол НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлэх үүрэгтэй байна. НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлсэн эсэхээс үл хамааран цахим төлбөрийн баримтыг олгоно. (Жич: 2027 оны 1 дүгээр сарын 1-с хүчин төгөлдөр үйлчлэхээр хуулинд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу борлуулалтын орлого 400,0 сая төгрөг хүрсэн өдөр НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлэхээр болсон).
- Сүлжээ хөгжүүлэгч "Вайб Пэй" ХХК-ийн банкин дахь харилцах дансаар ажил олгогч (харилцагч) байгууллагаас хүлээн авч, ажилтнуудын Вайб Пэй картыг цэнэглэж буй мөнгөн хөрөнгө нь "Вайб Пэй" ХХК-ийн борлуулалтын орлого биш бөгөөд тухайн мөнгөн хөрөнгийн бүртгэлийг харилцагч бүрээр бүртгэж, тооцоо нийлж, санхүүгийн анхан шатны бүртгэл хөтөлж, нотлох баримтуудаар тухай бүр бэхжүүлж явах нь зүйтэй.

Гурав. Мерчант (Худалдаа үйлчилгээний газар)-ын хувьд:

Мерчант буюу хоол, хүнс үйлдвэрлэгч, борлуулагч худалдаа үйлчилгээний газар нь Вайб Пэй-н системээр төлбөр хүлээн авч, тухайн ажилтны ажил олгогчийн нэр дээр татварын цахим бүртгэлийн ebarimt-д системд борлуулалтыг бүртгэнэ. Энэ тохиолдолд мерчант (Худалдаа

үйлчилгээний газар)-ын татварын бүртгэл бусад борлуулалтын орлогын бүртгэлтэй ижил бүртгэгдэж тайлагнагдана.

Дөрөв. Ажилтан (Үйлчилгээ хүртэгч)-ийн хувьд:

Ажилтан хязгаарлагдмал эрхтэй Вайб Пэй цахим картаар сүлжээнд элссэн мерчант худалдаа үйлчилгээний газруудаас зөвхөн хоол, хүнс худалдан авах бөгөөд энэ нь бэлэн мөнгөөр олгогдоогүй мөн хөдөлмөрийн гэрээний дагуу олгож буй цалин, шагнал урамшуулал биш тул тухайн орлогоос ХХОАТ төлөхөөргүй байна.

Жич: Энэхүү зөвлөмжийг бидэнд ирүүлсэн тайлбар бүхий албан бичиг, захирал А.Цэлмэг-тэй ярилцсан ярилцлага дээр үндэслэн боловсруулсан бөгөөд санхүүгийн анхан шатны баримт бүртгэлтэй танилцаагүй болохыг дурдах нь зүйтэй.

[Тамга: "Улаанбаатар хот — ТАКС ТАЙМ ТМЗ ХХК"]

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ [гарын үсэг] **Ц.ЭНХНАРАН**